

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөхмөрөн сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М. Батсуурь

Утас: 70453317

Аудитын менежер: М. Бат-Амгалан

Утас: 70453799

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит

ХХК-ийн аудитор: С. Эрдэнэчимэг

Утас: 9902-3656

Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Цахим хаяг: ariuntuqsorshihuiiaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 3 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 9 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 4.2 Материаллаг байдал..... | 13 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал13 | |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... | 14 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УГА-2023/120/АД-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

БӨХМӨРӨН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.АЛИМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөхмөрөн сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөхмөрөн сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700151

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>47,446,052.70</u> | <u>65,416,601.52</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 7,361,183.82 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 7,361,183.82 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 7,361,183.82 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 7,361,183.82 |
| 33 | АВЛАГА | 13,500,000.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 13,500,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 13,500,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 33,946,052.70 | 58,055,417.70 |
| 354 | Хангамжийн материал | 33,946,052.70 | 58,055,417.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,031,052.90 | 4,141,252.90 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,485,879.80 | 49,825,614.80 |
| 35460 | Хүнсний материал | 429,120.00 | 4,088,550.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>744,896,758.51</u> | <u>736,132,518.94</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 744,896,758.51 | 736,132,518.94 |
| 392 | Биет хөрөнгө | 740,650,758.51 | 731,886,518.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 760,593,190.00 | 760,593,190.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -53,600,359.92 | -72,752,534.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 31,636,804.00 | 36,936,804.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -18,123,475.25 | -23,457,711.68 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,408,492.49 | 60,108,492.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,802,892.81 | -31,080,721.59 |
| 39217 | Ном | 1,539,000.00 | 1,539,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,246,000.00 | 4,246,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,246,000.00 | 4,246,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>792,342,811.21</u> | <u>801,549,120.46</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 300,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 300,000.00 |
| 413 | Өглөг | 00.00 | 300,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 300,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 300,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>792,342,811.21</u> | <u>801,249,120.46</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 792,342,811.21 | 801,249,120.46 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 594,882,847.00 | 594,882,847.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 594,882,847.00 | 594,882,847.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -47,180,939.91 | -38,274,630.66 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -47,180,939.91 | -47,180,939.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 8,906,309.25 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 244,640,904.12 | 244,640,904.12 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>792,342,811.21</u> | <u>801,549,120.46</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 241,384,400.00 | 319,427,435.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 00.00 | 00.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 212,671,700.00 | 21,126,835.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 21,126,835.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 21,126,835.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 21,126,835.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 212,671,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 212,671,700.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 28,712,700.00 | 298,300,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 252,930,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 252,930,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 180,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 180,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 28,532,700.00 | 45,370,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,532,700.00 | 45,370,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 254,817,303.08 | 310,521,125.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 254,817,303.08 | 310,521,125.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 242,594,897.54 | 297,954,367.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 151,022,715.00 | 183,238,052.00 |
| 210101 | Үндсэн цалин | 108,321,174.00 | 124,072,003.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,758,421.00 | 44,946,754.00 |
| 210104 | Урамшуулал | 11,903,120.00 | 12,539,295.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 1,680,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,502,631.46 | 22,971,984.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,570,697.81 | 15,770,882.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,516,946.15 | 1,855,397.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,216,580.66 | 1,484,318.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 290,764.58 | 351,035.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,907,642.26 | 3,510,351.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,252,598.00 | 26,983,105.03 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,469,862.00 | 2,200,369.03 |
| 210302 | Түлш, халаалт | 24,782,736.00 | 24,782,736.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,494,600.00 | 5,306,036.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 191,000.00 | 1,683,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,770,100.00 | 1,884,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 313,686.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 635,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 793,500.00 | 1,424,600.00 |

| | | | |
|--------|--|-----------------------|---------------------|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 105,000.00 | 00.00 |
| 2105 | Норматив зардал | 9,303,230.00 | 25,082,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,900.00 | 15,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,250,330.00 | 25,067,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 800,000.00 | 2,687,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 2,687,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 768,000.00 | 300,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 480,000.00 | 300,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,451,123.08 | 31,384,789.57 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,230,200.00 | 1,067,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,220,923.08 | 28,764,239.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,222,405.54 | 12,566,758.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 490,000.00 | 11,146,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 490,000.00 | 11,146,100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 11,732,405.54 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 1,420,658.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,420,658.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>-13,432,903.08</u> | <u>8,906,309.25</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 145,562.50 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 145,562.50 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -145,562.50 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-13,578,465.58</u> | <u>8,906,309.25</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>241,384,400.00</u> | <u>298,300,600.00</u> |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 00.00 | 00.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 212,671,700.00 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 212,671,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 212,671,700.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 28,712,700.00 | 298,300,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 252,930,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 252,930,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 180,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 180,000.00 | 00.00 |

| | | | |
|--------|---|-----------------------|-----------------------|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 28,532,700.00 | 45,370,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,532,700.00 | 45,370,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 241,384,400.00 | 290,939,416.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 241,384,400.00 | 290,939,416.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 229,161,994.46 | 278,372,657.91 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 151,022,715.00 | 183,238,052.00 |
| 210101 | Үндсэн цалин | 108,321,174.00 | 124,072,003.00 |
| 210102 | Нэмэгдэл | 25,758,421.00 | 44,946,754.00 |
| 210104 | Урамшуулал | 11,903,120.00 | 12,539,295.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 1,680,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,502,631.46 | 22,971,984.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,570,697.81 | 15,770,882.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,516,946.15 | 1,855,397.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,216,580.66 | 1,484,318.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 290,764.58 | 351,035.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,907,642.26 | 3,510,351.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,252,598.00 | 26,983,105.03 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,469,862.00 | 2,200,369.03 |
| 210302 | Түлш, халаалт | 24,782,736.00 | 24,782,736.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,993,300.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 181,500.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,770,100.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 788,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,253,700.00 | 00.00 |
| 2105 | Норматив зардал | 10,119,450.00 | 28,727,230.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,679,450.00 | 28,727,230.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 440,000.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 800,000.00 | 2,249,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 2,249,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 768,000.00 | 55,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 288,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 480,000.00 | 55,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,703,300.00 | 14,147,686.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 11,955,286.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,703,300.00 | 2,192,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,222,405.54 | 12,566,758.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 490,000.00 | 11,146,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 490,000.00 | 11,146,100.00 |

| | | | |
|--------|--|---------------|--------------|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 11,732,405.54 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 1,420,658.27 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,420,658.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 7,361,183.82 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 7,361,183.82 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 7,361,183.82 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| D01 | 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 594,882,847.00 | 244,640,904.12 | -47,180,939.91 | 792,342,811.21 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 594,882,847.00 | 244,640,904.12 | -47,180,939.91 | 792,342,811.21 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 8,906,309.25 | 8,906,309.25 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 594,882,847.00 | 244,640,904.12 | -38,274,630.66 | 801,249,120.46 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

/Төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|-----------------------------------|----------------|----------------|---------------|--------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 252,930,100.00 | 245,568,916.18 | 7,361,183.82 | 97.09 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 252,930,100.00 | 245,568,916.18 | 7,361,183.82 | 97.09 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 241,784,000.00 | 234,422,816.18 | 7,361,183.82 | 96.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 172,737,800.00 | 170,086,669.00 | 2,651,131.00 | 98.47 |
| 210101 | Үндсэн цалин | 142,897,100.00 | 114,966,133.00 | 27,930,967.00 | 80.45 |
| 210102 | Нэмэгдэл | 25,731,300.00 | 43,446,888.00 | 17,715,588.00 | 168.85 |
| 210104 | Урамшуулал | 4,109,400.00 | 11,673,648.00 | -7,564,248.00 | 284.07 |

| | | | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|----------------------|----------------|
| 210102 | Нэмэгдэл | 25,731,300.00 | 43,446,888.00 | 17,715,588.00 | 168.85 |
| 210104 | Урамшуулал | 4,109,400.00 | 11,673,648.00 | -7,564,248.00 | 284.07 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,974,700.00 | 21,406,231.18 | 568,468.82 | 97.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,065,300.00 | 14,671,567.20 | 393,732.80 | 97.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,727,300.00 | 1,726,066.69 | 1,233.31 | 99.93 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,381,900.00 | 1,380,853.37 | 1,046.63 | 99.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 345,400.00 | 329,794.88 | 15,605.12 | 95.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,454,800.00 | 3,297,949.04 | 156,850.96 | 95.46 |
| 2105 | Нормативт зардал | 32,388,800.00 | 28,727,230.00 | 3,661,570.00 | 88.69 |
| 210502 | Хоол, хүнс | 32,388,800.00 | 28,727,230.00 | 3,661,570.00 | 88.69 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 444,000.00 | 55,000.00 | 389,000.00 | 12.39 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444,000.00 | 55,000.00 | 389,000.00 | 12.39 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,238,700.00 | 14,147,686.00 | 91,014.00 | 99.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,988,700.00 | 11,955,286.00 | 33,414.00 | 99.72 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,250,000.00 | 2,192,400.00 | 57,600.00 | 97.44 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,146,100.00 | 11,146,100.00 | 0.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,146,100.00 | 11,146,100.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,146,100.00 | 11,146,100.00 | 0.00 | 100.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 252,930,100.00 | 252,930,100.00 | 0.00 | 100.00 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 252,930,100.00 | 252,930,100.00 | 0.00 | 100.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 252,930,100.00 | 252,930,100.00 | 0.00 | 100.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 7,361,183.82 | -7,361,183.82 | #DIV/0! |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 13 | 13 | | |
| 134 | Удирдах ажилтан | 1 | 1 | | |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 6 | 6 | | |
| 136 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | | |
| 137 | Гэрээт ажилтан | 1 | 1 | | |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

/Төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|----------------------|----------------------|---------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 96.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 96.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 96.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 13,651,200.00 | 13,151,383.00 | 499,817.00 | 96.34 |
| 210101 | Үндсэн цалин | 11,971,200.00 | 9,105,870.00 | 2,865,330.00 | 76.06 |
| 210102 | Нэмэгдэл | 0 | 1,499,866.00 | -1,499,866.00 | 0 |
| 210104 | Урамшуулал | 0 | 865,647.00 | -865,647.00 | 0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,680,000.00 | 1,680,000.00 | 0.00 | 100 |

| | | | | | |
|--------|--|---------------|---------------|--------------|-------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,706,500.00 | 1,565,753.70 | 140,746.30 | 91.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,160,400.00 | 1,099,315.61 | 61,084.39 | 94.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 136,400.00 | 129,330.83 | 7,069.17 | 94.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 109,300.00 | 103,465.06 | 5,834.94 | 94.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 27,300.00 | 21,240.20 | 6,059.80 | 77.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 273,100.00 | 212,402.00 | 60,698.00 | 77.77 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,732,700.00 | 26,983,105.03 | 749,594.97 | 97.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,950,000.00 | 2,200,369.03 | 749,630.97 | 74.59 |
| 210302 | Түлш, халаалт | 24,782,700.00 | 24,782,736.00 | -36.00 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,280,100.00 | 2,249,600.00 | 30,500.00 | 98.66 |
| 210604 | Урсгал засвар | 2,280,100.00 | 2,249,600.00 | 30,500.00 | 98.66 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 100 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 100 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 45,370,500.00 | 43,949,841.73 | 1,420,658.27 | 100 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөхмөрөн сумын цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд тус цэцэрлэг нь "Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлэх, бусадтай хамтран аз жаргалтай бүтээлчээр тоглож, наадах, эрүүл аюулгүй орчинд өсөн бойжих боломж олгоход оршино" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"

- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөхмөрөн сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,206.3 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|------------------|----------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 7,361.1 | 7,361.1 |
| Авлага | 13,500.0 | 0.0 | -13,500.0 |
| Бараа материал | 33,946.0 | 58,055.4 | 24,109.3 |
| Үндсэн хөрөнгө | 744,896.7 | 736,132.5 | -8,764.2 |
| Нийт хөрөнгө | 792,342.8 | 801,549.1 | 9,206.3 |
| Өр төлбөр | 0.0 | 300.0 | 300.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 792,342.8 | 801,249.1 | 8,906.3 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 792,342.8 | 801,549.1 | 9,206.3 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,361.1 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлгүй болж 13,500.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд ковидын нөхцөл байдалтай холбоотой 2021 оны 12-р сарын 31-нд хөрөнгө хүлээн зөвшөөрөлтийн шалгуур бүрэн хангаагүй байсан учир шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна. 2022 онд тухайн авлага бүрэн барагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,055.4 мянган төгрөг болж 24,109.3 мянган төгрөгөөр буюу 71 хувь өссөн байна. Энэ өсөлт нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх цагаан хэрэглэл, ангиуд, гал тогоонд аж ахуйн болон сургалтын хэрэглэгдэхүүн авч байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 736,132.5 мянган төгрөг болж 8,764.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр данс нь 300.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх өр үүссэнтэй холбоотой байна. Энэ онд харилцагч байгууллагуудтай холбоотой өр төлбөр нь тооцооны үлдэгдлээр баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 801,249.1 мянган төгрөг болж 8,906.3 мянган төгрөг ба 1.1 хувиар буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 430,529.5 мянга, орон нутгийн төсвөөс 45,370.5 мянга төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 177,599.4 мянган төгрөгийг бууруулж, 298,300.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 252,930.1 мянга, орон нутгийн төсвөөс 45,370.5 мянга, нийт 298,300.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 252,930.1 мянга, орон нутгийн төсвөөс 45,370.5 мянга, нийт 298,300.6 мянган төгрөгийн төсвийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 289,518.7 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг орон нутгийн төсөвт 1,420.6 мянган төгрөг буцаан төвлөрүүлж, улсын төсвийн дансанд 7,361.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ | |
|-----|-----------------------|------------|-----------|--------------------|---------|
| | | | | Зөрүү | Биелэлт |
| 1 | Улсын төсөв | 252,930.1 | 245,568.9 | 7,361.2 | 97.1% |
| 2 | Орон нутгийн | 45,370.5 | 43,949.8 | 1,420.6 | 96.8% |

Цэцэрлэгийн хүүхдийн хоол хөтөлбөр, арга хэмжээний хувьд өвлийн улиралд ханиад томуу дэгдэлттэй холбоотой мөн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өвлийн амралтын хугацаа эхлэх үед хүүхдийн ирцийн хувь төлөвлөсөн хэмжээнээс эрс буурсантай холбоотойгоор 3,661.6 мянган төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлага гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баялаг, аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Бөхмөрөн сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 254,817.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,548.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 310,521.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 3,105.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,484.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроосон 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бөхмөрөн сумын Цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгагдаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байна.

одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус

байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс тайлант хугацаанд 81,909.5 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 46,534.6 мянган төгрөгийн худалдан авалт нь и баримтаар баталгаажаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бөхмөрөн сумын цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| | Нийт зөрчил | Үүнээс |
|--|-------------|--------|
| | | |

| Зөрчлийн товч утга | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--|-----|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Батсуурь* /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР *М.Бат-Амгалан* /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”
ХХК-ийн АУДИТОР *С.Эрдэнэчимэг* /С.ЭРДЭНЭЧИМЭГ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

